132

# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2014 оны 10 сарын 06 өдөр Дугаар 234 Мандалговь

Үнэлгээ тогтоох тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 20 тоот тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн дагуу хураагдсан үндсэн хөрөнгийг хадгалах, үнэлэх, худалдах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сум дундын шүүхийн шийтгэх тогтоолоор орон нутгийн орлого болгохоор шийдвэрлэгдсэн 6 ширхэг мотоциклийн худалдах доод үнийг үнэлгээний комиссын саналыг үндэслэн хавсралтын дагуу баталсугай.

2. Мотоциклуудыг батлагдсан үнийн дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА С.БУДЖАВ

0100490

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 10 сарын
06 өдрийн 234 -р тогтоолын хавсралт

Худалдах эд хөрөнгө

| № | Нэр төрөл | Тоо ширхэг | Улсын дугаар | Марк | Өнгө | Худалдах доод үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мотоцикл | 1 | Дугааргүй | Хэнсим | Улаан | 70'000 |
| 2 | Мотоцикл | 1 | Дугааргүй | Хонгор | Улаан | 70'000 |
| 3 | Мотоцикл | 1 | 08-74 ДУЗ | Хэнсим | Цэнхэр | 80'000 |
| 4 | Мотоцикл | 1 | Дугааргүй | Daelim | Саарал | 20'000 |
| 5 | Мотоцикл | 1 | Дугааргүй | Мустанг-5 | Улаан | 350'000 |
| 6 | Мотоцикл | 1 | 29-20 ДУЗ | Чанса | Улаан | 70'000 |